

## 2

### СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ, ЦААШДЫН ЗОРИЛТ

---

**Б.Батмөнх**

МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхим үүсэн байгуулагдаад 50 дахь хичээлийн жилдээ сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд статистикийн шинжлэх ухаан, практикийн хөгжил, цаг үеийн эрэлт, хэрэгцээнээс хамаараад эдийн засаг, статистикийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр байнга өөрчлөгдөн шинэчлэгдсээр ирсэн. 1990 оноос Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, нийгмийн амьдралын орчин өөрчлөгдөж, боловсролын салбарын өмнө өвөрмөц шинэ шаардлагууд гарч ирсэн билээ. Иймээс сургалтын хөтөлбөрөө цаг үеийнхээ шаардлагад нийцүүлэн сайжруулах явдал сургалтын бодлого, үйл ажиллагааны нэн тэргүүнд анхаарсаар ирсэн асуудал байсан бөгөөд сургалтын хөтөлбөрт чанарын баталгаа бий болгох нэг чухал нөхцөл нь үндэсний болон олон улсын түвшинд сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх явдал юм.

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл бол уг хөтөлбөрийн чанар, ач холбогдлыг үнэлсэн, элсэн суралцагчид, төгсөгчддөө тухайн мэргэжлээр цаг үеийн шаардлагад нийцсэн, ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагуудыг хангасан өндөр түвшний мэдлэг, ур чадвар олгох баталгаа бий болгож байгаа чухал үнэлгээ гэдгийг та бид мэднэ. Манай орны төрийн болон хувийн хэвшлийн 150 гаруй их, дээд сургуулиас 2010 оны эцсийн байдлаар 70 орчим их, дээд сургууль магадлан итгэмжлэгдсэн байв. Харин хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зөвхөн 10 их, дээд сургуулийн 40 гаруй хөтөлбөр хамрагджээ. Зарим томоохон сургуулиар авч үзэхэд ШУТИС 23 хөтөлбөр, ХААИС 8 хөтөлбөр, МУИС зөвхөн 2 хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн бөгөөд энэхүү 2 хөтөлбөр нь ЭЗС-ийн нягтлан бодох бүртгэл болон маркетингийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр юм. Эндээс харахад магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр харьцангуй цөөхөн байгаа болно.

Манай тэнхмийн хамт олон эдийн засаг, статистикийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх чанарыг шинэ түвшинд гаргах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэхээр урьдчилсан шаардлагын биелэлтийг гаргаж, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлд (БМИҮЗ) 2010 оны 5 сард хүргүүлж, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангаа бичих эрхээ авч, улмаар магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайлангаа бэлтгэж хүргүүлээд байна. Үүний зэрэгцээ ЭЗС өнгөрсөн хичээлийн жилийн 5 дугаар сард бакалаврын хөтөлбөрүүдээ олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оруулахаар АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбооны гишүүнээр элсэж, энэхүү холбооны стандарт шаардлагуудыг хангахаар бэлтгэж байна.

Гадаад, ялангуяа дотоодын магадлан итгэмжлэлд орох ажил нь цаг хугацаа их шаардсан амаргүй ажил байсан боловч тэнхмийн багш нар гар нийлэн ажиллаж ийм түвшинд хүрээд байгаа амжилтаар тэнхмийнхээ 50 жилийн ойг угтаж байгаадаа баяртай байна. МУИС-ийн ЭЗС-ийн эдийн засаг, статистикийн мэргэжилтэй мэргэжилтэн бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний энэхүү тайланг бэлтгэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа хамт олон өөрийн давуу талаа олж харж, мөн хөтөлбөрийн сул тал, цаашид сайжруулах шаардлагатай зүйлээ тодорхойлж, тэдгээрийг ажил хэрэг болгох арга замаа төлөвлөх боломж олсноороо чухал ач холбогдолтой ажил боллоо.

Єрийн үнэлгээний энэхүү тайланг БМИҮЗ-өөс гаргасан магадлан итгэмжлэл явуулахад баримтлах 3 багц шалгуурт байгаа 53 шалгуур үзүүлэлт тус бүрээр эдийн засаг, статистик мэргэжлээр дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн өнөөгийн байдлаа үнэлж, давуу, онцог талаа харуулж, сул тал, анхаарах асуудлаа тодорхойлох замаар үнэлгээг хийсэн болно.

Өөрийн үнэлгээний онооны дүнг 3 үндсэн бүлгээр болон нийт дүнгээр харуулав.

1.Сургалтын хөтөлбөрийн зорилго, бодлого, төлөвлөлт	Авбал зохих оноо	104	Хувь
	Авсан оноо	98	94,7
2.Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчин, нөөц	Авбал зохих оноо	88	Хувь
	Авсан оноо	77	87,5
3.Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хүний хүчин зүйлс	Авбал зохих оноо	232	Хувь
	Авсан оноо	211	90,9
Өөрийн үнэлгээний ерөнхий дүн	Авбал зохих оноо	424	Хувь
	Авсан оноо	386	91,0

Өөрийн үнэлгээний энэхүү тайлангаар 3 бүлэг, 53 шалгуур үзүүлэлтээр нийт авбал зохих 424 онооноос 386 оноо авч, хөтөлбөр бүхэлдээ 91 хувьтай үнэлэгдлээ.

Бүлэг тус бүрийн шалгуур үзүүлэлтүүдийн тоог оноогоор харуулбал

	8 оноотой	7 оноотой	6 оноотой	Дүн
1.Сургалтын хөтөлбөрийн зорилго, бодлого, төлөвлөлт	7	6	-	13
2.Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчин, нөөц	1	9	1	11
3.Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хүний хүчин зүйлс	10	16	3	29
<b>ДҮН</b>	<b>18</b>	<b>31</b>	<b>4</b>	<b>53</b>

Нийт 18 шалгуураар хамгийн өндөр оноо авсан нь МУИС-ийн ЭЗС-ийн эдийн засаг, статистикийн мэргэжилтэй мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөр нь өөрийн онцлог хүчтэй давуу талуудтай болохоо харуулсан. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг хөтлөн явуулах эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн. МУИС-ийн одоогийн мөрдөж байгаа дүрэм, журмууд нь орчин үеийн зах зээлийн нөхцөл дэх боловсролын тогтолцооны хэв маягт тулгуурласан байнга боловсронгуй болон сайжирсаар ирсэн. Энэхүү хичээлийн жилд мөн улам боловсронгуй болгон өөрчилж байна.
- Эдийн засаг, статистик мэргэжлийн MNS 5323-42 дугаартай стандартыг 2008 онд тус тэнхмийн багш нар өөрсдөө боловсруулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр батлуулан мөрдөж ирсэн давуу талтай бөгөөд энэ мэргэжлээр манай оронд батлагдсан үндсэн стандарт болон мөрдөгдөж байна.
- ЭЗС-ийн эдийн засаг, статистикийн мэргэжилтэй мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн багш нар нь их, дээд сургуулийн багшид тавигддаг нийтлэг шаардлагуудыг ихээхэн давуулан хангаж байгаа нь үнэлгээгээр гарлаа.

**Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж - статистикийн тэнхмийн багшийн тоо, хүрэлцээ хангамж**

Стандарт шаардлага	2010/2011 оны хичээлийн жилийн байдлаар хүрсэн түвшин
1. Нэг багшид ногдох оюутны тоо 20-иос ихгүй	18 оюутан
2. Нийт багш нарын 60 хувиас доошгүй нь орон тооны багш байна.	80%
3. Үндсэн багш нарын 15 түүнээс дээш хувь нь эрдмийн цол зэрэгтэй байх	Докторын зэрэгтэй 6 багш байгаа нь үндсэн багш нарын 75 хувь болж байна.

Тэнхмийн 1 залуу багш өндөр хөгжилтэй оронд докторын зэрэг хамгаалж улмаар докторын дараахь судалгааны ажлаа дуусгаж ирээд ажиллаж байгаа бол нөгөө нэг залуу багш нь БНСУ –д докторын зэрэг хамгаалахаар сурч байгаа нь цаашид багш нарын бүрэлдэхүүн улам сайжрах хандлагатай байна.

- ЭЗС нь олон улсын магадлан итгэмжлэлд орохоор идэвхтэй бэлтгэж байгаа нь энэхүү хөтөлбөр нь мэргэжлийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын түвшинд хүрэх чиг хандлага нь улам тодорхой байгаа илт давуу талтай байгаа юм.
- МУИС, түүний ЭЗС нь сургалтыг үйл ажиллагаанд хэрэглэдэг SiSi программыг сүүлийн 2 жилд амжилттай нэвтрүүлж, орчин үеийн мэдээллийн технологийг сургалтанд ашиглах, сургалтын үйл ажиллагааг ил, тод, оюутан сурагчдад хүртээмжтэй болгох талаар шинэлэг ажлыг хэрэгжүүлж ирсэн давуу талтай.
- Сүүлийн жилүүдэд эдийн засаг, статистикийн мэргэжлээр суралцаж байгаа бакалаврын өдрийн ангийн оюутнуудын эрдэм шинжилгээний ажлын тоо, чанарын түвшин нэмэгдаж, ЭЗС-ийн хэмжээндээ эхний байруудад шалгардаг болоод байгаа зэрэг олон давуу, хүчтэй талууд байгаа нь өөрийн үнэлгээгээр тогтоогдсон.

Үүний зэрэгцээ өөрийн үнэлгээний тайлангаар хамгийн бага оноо авсан 4 шалгуур үзүүлэлт анхаарал татаж байгаа бөгөөд эдгээрийг жагсаавал:

- Хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйд үндсэн сурах бичигтэй байх ба хүртээмжтэй байх шалгуур юм. Статистикийн чиглэлийн ном сурах, бичгийн хангалт тааруу байгаа нь энд бага үнэлгээ авах шалтгаан болсон.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлсэн байх ба нөөц судалгаатай байх шалгуурын хувьд багш нарын хангамж хүрэлцээ сайн биш, нөөц багшийг бэлтгэж чадаагүй тасарсантай холбоотойгоор бага үнэлгээ авсан болно.
  - Багшийнцагийн ачаалал ньтохиромжтой байх ба хичээлийн бэлтгэлийг хангах, суралцагчидтай хамтран ажиллах, өөрийнхөө мэдлэг, мэргэжлийг дээшлүүлдэг байх шалгуурын хувьд тус тэнхимд хэдийгээр 10 багш харьяалалтай ч зарим нэг нь гадаадад сурч байгаа, гадаадад судлаач багшаар ажиллах зэрэг шаардлагын улмаас, мөн бүтэн бус хэлбэрээр (50 хувиар) ажилладаг багш 4 байгаа нь залуу багш нар илүү цагаар ажиллахад хүрч, тэдэнд хүндээр тусч, цагийн ачаалал нь хэтрэх, зарим тохиолдолд илүү хийсэн цагийн хөлсөө дутуу авахад хүргэж байна. Энэ байдал нь үнэлгээг багаар тавихад хүргэжээ.
1. Багш хичээл сургалтандаа хувь оюутны сурах чадвар, чадамжийг харгалзан үздэг байх, түүнийг хөтөлбөрт тусгасан байх шалгуур доогуур үнэлэгдсэн нь тодорхой нэг хичээлийн хөтөлбөр нь оюутны сурах чадварт тааруулсан хөнгөрүүлсэн болон хүндрүүлсэн хувилбар байдаггүйтэй холбоотой байна.

Өөрийн үнэлгээний тайлангаас харахад эдийн засаг, статистикийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг цаашид боловсронгуй болгон сайжруулахад анхаарах асуудал нь тэргүүн ээлжинд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчин, нөөцийг цаашид сайжруулах, нэмэгдүүлэх, дээр бага оноотой үнэлэгдсэн шалгууруудыг хангахад чиглэгдсэн байх шаардлага гарч байна.

Магадлан итгэмжлэлд оруулахаар бэлтгэсэн сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг үндэслэн SWOT шинжилгээг дараах байдлаар хийв.

**Хүснэгт-1. Статистикийн тэнхмийн үйл ажиллагаанд хийсэн SWOT шинжилгээ**

<b>Давуу тал - Strengths</b>	<b>Сул тал - Weaknesses</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засаг, статистикийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж ирсэн 50 жилийн баялаг түүх, уламжлалтай</li> <li>• МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн хувьд улс орондоо харьцангуй өндөр нэр хүндтэй</li> <li>• Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг хөтлөн явуулах эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн</li> <li>• Багшлах бүрэлдэхүүн өндөр хөгжилтэй орнуудад доктор, докторын дараах сургал-танд хамрагдсан чадварлаг залуу багш нараар сэлбэгдэж байгаа</li> <li>• МУИС, түүний ЭЗС нь сургалтыг үйл ажиллагаанд хэрэглэдэг SiSi программыг сүүлийн 2 жилд амжилттай нэвтрүүлж, орчин үеийн мэдээллийн технологийг сургалтанд ашиглах, сургалтын үйл ажиллагааг ил, тод, оюутан сурагчдад хүртээмжтэй болгох талаар шинэлэг ажлыг хэрэгжүүлж ирсэн давуу талтай.</li> <li>• Компьютерын бие даасан лаборатортой, анги, тэнхим, сургалтын тоног төхөөрөмжийн хуьд боломжийн хангагдсан</li> <li>• МУИС-ийн ЭЗС-ийн дотроо мэргэжлийн стандарттай 5 хөтөлбөрийн нэг нь уг тэнхмийн хөтөлбөр юм</li> <li>• Тэнхмийн сургалтын хөтөлбөрийг үндэсний магадлан итгэмжлэлд оруулахаар өөрийн үнэлгээний тайлангаа бичсэн.</li> <li>• Ойрын 3 жилд ЭЗС нь олон улсын магадлан итгэмжлэл хийлгэхээр бэлтгэж байгаа тул цаашдаа тэнхмийн сургалтын хөтөлбөр нь олон улсын жишигт хүрэх өндөр магадлалтай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ЭЗС-ийн дотроо мэргэжлийн бус ангиудад ордог зарим хичээлийн агуулга мэргэжлийн онцлогтой сайн уялдаагүй, жишээлбэл, магадлалын онол хичээлийг санхүүгийн мэргэжлийн оюутнуудад заахдаа мэргэжлийн онцлогт нь тохируулан заахад анхаарах</li> <li>• ЭЗС-ийн дотроо тэнхим дундын эконометрик зэрэг зарим хичээлийг заах талаар бусад тэнхмүүдтэй өрсөлдөх чадвар дутмаг</li> <li>• МУИС-ийн бүрэлдэхүүний бусад сургуулиудад хэрэгцээтэй хичээлүүдийг заах талаар уялдаа холбоо муутай ажиллаж байгаа</li> <li>• Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээ бага, багш нар ихэнх цагаа хичээл заахад зориулж байгаа</li> <li>• Багш нар томоохон төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд хамтран оролцох нь цөөн, боломжоо муу ашиглаж байгаа</li> <li>• Ижил төрлийн мэргэжлийн сургуулиудтай хамтын ажиллагаа сул</li> <li>• Гадаадын ижил мэргэжлийн сургууль, тэнхмүүдтэй байнгын хамтын ажиллагаа байхгүй</li> </ul>

<b>Боломж - Opportunities</b>	<b>Аюул - Threats</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг нэмэгдүүлэх боломжтой</li> <li>• Гадаад харилцаагаа өргөтгөх, оюутан багш солилцооны арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>• Судалгаа шинжилгээний төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх</li> <li>• Эконометрикийн сургалтын өрсөлдөх чадавхаа өсгөх</li> <li>• МУИС-ийн салбар сургуулиудад орох хичээлийн тоог нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Өрсөлдөгчдөдөө байр сууриа алдах, тэнхмүүдийн дундын хичээлийг өөр тэнхим, багш нарт алдах</li> <li>• Мэргэжлийн эрэлт хэрэгцээ буурч, элсэгчдийн тоо буурах</li> <li>• Өндөр боловсролтой багш нар нь цалин ихэй өөр ажилд шилжин явах, багшлах боловсон хүчний хангамж багасах</li> <li>• Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар ажил олгогчдын эрэлт хэрэгцээг хангахгүй гологдох</li> </ul>

SWOT шинжилгээнээс харахад давуу тал, боломжуудын зэрэгцээ тодорхой түвшинд цөөнүй сул тал, бас аюул заналын шинжтэй хүчин зүйлс байгаа нь харагдлаа. Энэ бүхнийг үндэслээд тэнхмийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрөө цаашид улам сайжруулах зорилтуудыг дараах байдлаар тодорхойллоо.

### **Тэнхмийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэл, стратеги**

#### **□ Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлүүд**

1.1. Ажил олгогчид, бизнесийн байгуулагатай нягт хамтран ажиллаж, өнөөгийн нөхцөлд төгсөгчдөд ажлын байранд тавигдаж байгаа шаардлагуудыг нарийвчлан тодорхойлж, түүнд сургалтын хөтөлбөрөө түлхүү чиглүүлэн өөрчлөх. Үүний тулд МУИС-ийн түвшинд ч өөрчлөлт шинэчлэлт шаардагдаж болно. Гол нь МУИС-ийн удирдах зөвлөлд улс төрчид, дарга нарыг бус харин бизнесийн сайн удирдагчид, ажил олгогчдын төлөөлийг бий болгох шаардлага гарна.

1.2. Одоогийн хэт академик сургалтыг хэрэглээ тал уруу нь чиглүүлэн өөрчлөх, одоогийн мэдлэгийг тэргүүн ээлжинд тавьсан сургалтыг “ур чадварыг” тэргүүн ээлжинд тавьж дээр нь мэдлэгийг олгоход чиглүүлэн өөрчлөх,

1.3. Хичээлийн агуулгыг бизнесийн мэргэжлийн ангиудад мэргэжлийн онцлогтой сайн уялдуулж заах чиглэлээр өөрчлөлт хийх.

1.4. Эдийн засаг, статистик мэргэжлийн ангийн оюутнуудын суралцах үйл ажиллагааны эцсийн үр дүнг хэмжих шалгууруудыг маш тодорхой тогтоож өгөх

1.5. Мэргэжлийн ангийн оюутнуудад хичээл заахдаа цуглуулсан болон хоёрдогч эх үүсвэрээс авсан статистик мэдээллийн эх олонлогт иж бүрэн шинжилгээ хийж, судалгааны ажилд статистикийн шинжүүрүүдийг ашиглаж, дүгнэлт хийдэг практик ур чадварыг гүнзгий эзэмшүүлэхэд чиглүүлэн одоогийн зааж байгаа хичээлүүдийг өөрчлөх

1.6. Семинарын хичээлүүдийг явуулахдаа статистикийн бодитой анхдагч мэдээлэл дээр, тухайлбал, ҮСХ-ноос явуулсан өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны анхдагч тоо мэдээлэл дээр ажилуулах, ийм мэдээлэлд тулгуурлан статисткийн үзүүлэлтүүдийг тооцох, статистикийн шинжилгээний аргуудыг хэрхэн хэрэглэх, ажиглахыг заадаг болоход түлхүү анхаарах, ялангуяа статистикийн хэрэглээний болон судалгааны тусгайлсан программуудаар орох хичээлийг заахдаа зөвхөн ийм мэдээллийг өргөн ашиглаж бодитой өгөгдөл дээр судалгаа, шинжилгээ хийхэд илүү анхаарах шаардлагатай болж байна.

1.7 Бүртгэл статистикийн болон нэгдсэн статистикийн дадлагын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд одоогийн дадлага хийж байгаа практикт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ.

### **Тэнхмийн үйл ажиллагааг сайжруулах чиглэл**

Статистикийн тэнхмийн эрхэм зорилго нь *“Өндөр боловсрол, өрсөлдөх чадвартай эдийн засаг-статистистикийн мэргэжлээр мэргэшсэн хувь хүнийг бэлтгэн, нийгмийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх”* явдал юм гэж тус тэнхимийн хамт олон стратегийн төлөвлөгөөндөө тодорхойлсон.

Статистик-эконометрикийн сургалт, судалгаагаараа үндэсний хэмжээнд тэргүүлэх үүрэгтэй эрдэм оюуны төв болж хөгжих зорилтыг алсын хараа болгон дэвшүүлсэн.

Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд тэнхмийн багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, өндөр хөгжилтэй оронд залуу багш нараа давтан сургах, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх явдал нэн тэргүүний шаардлага болж байна.

Багш нарын эрдэм шинжилгээний ур чадвар, чадавхийг нэмэгдүүлэх, гадаадад сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр МУИС болон ЭЗС-иас тусгай фонд байгуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Статистикийн тэнхмийн багш нар нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар хийх судалгааны ажлыг өргөн хүрээнд хийдэг, чадварлаг, туршлагатай баг болох ёстой.

Ном, сурах бичгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, сургалтын материаллаг орчинг сайжруулах явдал дараагийн чухал зорилт болж байна.

Багш нарын зүгээс оюутантай ажиллах ажиллагааг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр багшийн ажлын үнэлгээнд өөрчлөлт оруулах талаар одоо МУИС-ийн дотоод дүрэм, журам өөрчлөгдөж байгаа энэ үед саналаа багш нар сайн гаргамаар байна.